



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 380

Улаанбаатар хот

Үл хөдлөх хөрөнгө акталж, данснаас  
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.2.5, 6.4.3, 6.4.5, 6.4.6 дахь заалт, Мэргэжлийн хяналтын Улсын ахлах байцаагчийн 2021 оны 01-07-020/42 дугаар дүгнэлт, Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн 04 дүгээр дүгнэлтийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын шаардлага хангахгүй, засвар хийхэд эдийн засгийн хувьд үр ашиггүй болох нь тогтоогдсон 538,394,652.90 (таван зуун гучин найман сая турван зуун ерэн дөрвөн мянга зургаан зуун тавин хоёр төгрөг ерэн мөнгө) төгрөгийн балансын үнэ, 418,508,805.40 (дөрвөн зуун арван найман сая таван зуун найман мянга найман зуун таван төгрөг дөчин мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Уул уурхай хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал, “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Б.Мөнхбат нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, ашиглаж болох материалыг ялан тоолж ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган,

2.3. Хөрөнгийг акталж буулгасан газар (чөлөөлөгдөх талбай)-ыг тухайн байгууллагын эзэмшилд хэвээр үлдээж төрийн өмчийн үйлдвэрийн газрын барилга барихаас өөрөөр ашиглахгүй байх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132007779

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2021 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн  
 30 дугаар тогтоолын хавсралт

**"МОНГОЛРОСЦВЕТМЕТ" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД  
 БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Үл хөдлөх хөрөнгийн нэр, байршил	Ашиглалтад орсон он	Балансын үнэ /төгрөг/	Хууримтлагдсан элэгдэл /төгрөг/	Үлдэгдэл өртөг /төгрөг/
1	Орон сууцны барилга /48 айл Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг 22 хороо/	1970	222,643,747.42	222,643,747.42	-
2	Хөнгөн тэрэгний гараашийн барилга /Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг 22 хороо/	1986	86,304,573.00	53,497,412.26	32,807,160.74
3	Спорт заал болон халуун усны барилга /Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг 22 хороо/	1986	179,999,003.84	122,341,744.54	57,657,259.30
4	Цэвэр усны шугам	2017	20,695,592.73	2,027,875.09	18,667,717.64
5	Тохижилтийн хөрөнгө: /Гараашийн цементэн талбай, талбайн тохижилт тэмдэглэгээ /	2004	15,187,570.91	5,562,137.82	9,625,433.09
6	Орон сууцны барилгын орчны тохижилт /ногоон байгууламж, хайс, цементэн талбай/	1984	13,564,165.00	12,435,889.27	1,128,275.73
НИЙТ ДҮН			538,394,652.90	418,508,805.40	119,885,847.50
			(таван зуун гучин найман сая гурван зуун ерэн дөрвөн мянга зургаан зуун тавин хоёр төгрөг ерэн мөнгө)	(дөрвөн зуун арван найман сая таван зуун найман мянга найман зуун таван төгрөг дечин мөнгө)	(нэг зуун арван есөн сая найман зуун наян таван мянга найман зуун дечин долоон төгрөг тавин мөнгө)